



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 534

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Боловсролын их сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 68,216,800.00 (жаран найман сая хоёр зуун арван зургаан мянга найман зуун) төгрөгийн балансын үнэ, 1,732,800.00 (нэг сая долоон зуун гучин хоёр мянга найман зуун) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, Монгол Улсын Боловсролын их сургуулийн захирал Д.Мандах, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн
534 дугаар тогтоолын хавсралт



**Монгол Улсын Боловсролын их сургуулийн балансаас
"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн компанийн балансад
шилжүүлэх хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр	Тоноглолын нэр	Тоноглолын марк	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1			ХТП-ны барилга		ш	1	25,737,500.00	362,500.00	25,375,000.00
2	БЗД - ын 6 -р хороо	ХТП - 3825	Иж бүрэн тоноглолтой 6/0,4кВ-ын S-11 2*630 кВА чадал бүхий трансформатор, 10кВ-ын КСО 6ш, 0.4кВ-ын ШО-70 хайрцаг 7ш	2013.11.27	ком	1	40,830,875.00	1,317,125.00	39,513,750.00
3			10кВ ААБлу 3х240		м	270	1,648,425.00	53,175.00	1,595,250.00
НИЙТ ДҮН:							68,216,800.00 (жаран найман сая хоёр зуун арван зургаан мянга найман зуун)	1,732,800.00 (нэг сая долоон зуун гучин хоёр мянга найман зуун)	66,484,000.00 (жаран зургаан сая дөрвөн зуун наян дөрвөн мянган)